

**МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛЭС**

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА НАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэлд:

“XVIII.1.Улсын төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа, удаашралтай болон үйл ажиллагаа нь зогссон барилга байгууламжийн нөхцөл байдал, шалтгаан, шийдвэрлэх арга замын талаар Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авахыг холбогдох Засгийн газрын гишүүд, барилга байгууламжийн захиалагч нарт даалгав:

1.2024 онд шилжин хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг эрчимжүүлж, гэрээт ажлын тоо хэмжээ, гүйцэтгэлийг хянаж, үнийн өсөлтийг бодитойгоор тооцож, дүгнэхийг захиалагч нарт;

2.Хуульд заасан хугацаанд хэрэгжээгүй, 2023 онд ажлын гүйцэтгэл дутуу барилга байгууламжийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хүрээнд гүйцэтгэлийг 2023 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар дүгнэж, зайлшгүй шаардлагатай бол гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авахыг захиалагч нарт;

3.Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв батлагдсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг улсын төсвийн төсөлд тусгах асуудлыг нэгтгэн зохион байгуулахыг Сангийн сайд Б.Жавхланд;

4.Зураг төсөл зохиогч, гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас хуулиар тогтоосон хугацаанд ашиглалтад оруулаагүй зохиогч, гүйцэтгэгчийн тусгай зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хүчингүй болгох арга хэмжээ авахыг тусгай зөвшөөрөл олгосон төрийн захиргааны төв байгууллагуудад, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгчийг хар жагсаалтад оруулахыг Сангийн сайд Б.Жавхланд, холбогдох мэдээллийг Сангийн яаманд хүргүүлж ажиллахыг захиалагч нарт;

5.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн талаарх мэдээлэл болон улсын комисст хүлээн авсан эсэх талаарх мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, олон нийтэд нээлттэй мэдээлэх боломж бүрдүүлэхийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн нарт;

6.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтыг худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага зохион байгуулах, барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгоходоо тухайн компанийн туршлага, хүчин чадалд үндэслэн хуулийн дагуу ажиллахыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт;

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР	
ТУС1786	
Бүртгэсэн № ...	Карт № ...
Огноо .....	.....
..... цаг .....	минутанд
.....	-д
шилжүүлэв.	
Хуудасны тоо .....	

7.Төрийн байгууллагын холбогдох албан тушаалтан, хуулийн этгээд нь ажлын даалгавар, зураг төсөл, мэргэжлийн дүгнэлт, барилга байгууламж, төсөл, арга хэмжээний төсвийн тооцооллыг буруу тооцсон, хариуцлагагүй хандсан зөрчлүүдэд хуулийн хүрээнд хариуцлага тооцох эрх зүйн орчныг сайжруулж, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт;

8.Улсын төсвөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээнд зориулж олгогдсон газар, замын чиг траст давхцуулж газар олгосон бүх шатны Засаг даргын захирамжийг газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд бүртгэхгүй байх, мэдээллийн сангаар дамжуулан хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт;

9.Бүтээн байгуулалтын хүрээнд хийгдэх төсөл, арга хэмжээний газар чөлөөлөх зардлыг шийдвэрлэх зохицуулалтыг боловсронгуй болгох, газар чөлөөлөх зардлыг тухай бүр тооцоолон тухайн төсөл, арга хэмжээний төсөвт зардлын хамт танилцуулж байх, төсөл, арга хэмжээний явцад газрын байршлыг өөрчлөхгүй байхад анхаарч, хяналт тавьж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт;

10.Зураг төсөл нь батлагдсан, газар эзэмших, ашиглах зөвшөөрөлтэй, инженерийн дэд бүтэц нь шийдэгдсэн барилга байгууламжийн төслийг улсын төсвөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналд тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт;

11.Барилгын хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төв, Зам тээврийн хөгжлийн төв зэрэг магадлал хийх, захиалагчийн хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий субъектуудын үйл ажиллагааг сайжруулан хариуцлагжуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх боломжийг судлан, санал боловсруулж танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт;

12.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн боловч ашиглалтад орохгүй үйл ажиллагаа нь бүрэн зогссон, удааширсан барилга байгууламжийн талаар нэгдсэн судалгаа хийж, шийдвэрлэх санал боловсруулах Ажлын хэсэг байгуулж, санал дүгнэлтийг 2023 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатарт." гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

